





Б.ЖАВХЛАН



Б.ЧОЙЖИЛСҮРЭН



Л.ГАНТӨМӨР



Б.БАТЦЭЦЭГ



О.АЛТАНГЭРЭЛ

**“ЭРЧИМ ХҮЧ-3 ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛС, ОЛОН УЛСЫН
СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэл, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07 дугаар захирамжийг үндэслэн “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр гарын үсэг зурсан.

“Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээн ийн санал

“Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд Багануур-Чойр чиглэлийн 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадварыг нэмэгдүүлж, Багануур, Чойр дэд станцуудын өргөтгөн, өсөн нэмэгдэж буй бус нутгийн эрчим хүчиний хэрэглээг найдвартай ажиллагаагаар хангах ач холбогдолтой юм.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулттай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.